



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 4/93

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.15, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.11.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн орлого бүрдүүлэх, төрийн үйл ажиллагааг хэвийн явуулах санхүүжилтийг бий болгоход чухал үүргийг гүйцэтгэж байгаа аймгийн Татварын хэлтсээс нийт татвар төлөгчдийн дунд зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, татварын байгууллагын албан хаагчдийн ажиллах нөхцөл боломжийг сайжруулах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зардалд 15,000.000 (Арван таван сая) төгрөгийг зарцуулсугай.


2. Батлагдсан төсвийг аймгийн Засаг даргын Тамгын газрын “Эрх зүй нийгмийн хэв журам” хөтөлбөрийн “Засаг дарга хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөрийн хөтөлбөрийг хэрэгжилт хангах” арга хэмжээний зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Э.Улам-Өсөх/, нягтлан бодогч /Э.Анхцэцэг/ нарт зөвшөөрсүгэй.

3. Санхүүгийн анхан шатны болон архивын баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Э.Анхцэцэг/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /М.Хуягбаатар/-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



6712010292